



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/34.

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн 5, 6 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8, 35 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1205 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
- 2.Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнахыг холбогдох албан хаагчдад үүрэг болгосугай.
- 3.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТЦЭЦЭГ

Хүвь:
Хянасан:
Боловсролын үнэмлэхийн үйлчилгээний газар (Хүний нөөц, мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх)

С. Энхтөг
Б. Энхтөг



Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026 оны 03 дугаар сарын 04 ний өдрийн 1/34 дүгээр тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны 03 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хариуцах нэгж
1	2	3	4	5	6
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулан олон нийтэд хүргэх;	-Баримтжуулсан байх; -Үр дүнг тооцож, тайлагнасан байх (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо);	Жилдээ	ЭБАТ
		1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	-Нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	ЭБАТ, ХЭЗХ, Нийт албан хаагчид
		1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 1-110” мэдээллийн самбар ажиллуулах;	-Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	ЭБАТ
		1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий	-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;	Жилдээ	ЭБАТ, Ёс зүйн дэд хороо, ХЭЗХ,

1	2	3	4	5	6
		(шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошюр зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.	-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; -Авлигыг мэдээлэх 1-110 дугаарыг оруулсан байх.		МТХ
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	4 дүгээр улиралд	ЭБАТ, ЗСХ
		2.2.Тендерт оролцогч аж ахуйн нэгж байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Тухай бүр	ЭБАТ, МТХ
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-Гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах;	-	ХЭЗХ, Ахлах нягтлан бодогч Нийт албан хаагчид

1	2	3	4	5	6
			-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.		
		3.2.Монгол улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх.	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.	Жилдээ	ХЭЗХ, Дотоод аудитор, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м);	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	ЭБАТ, ТХААХ, ХЭЗХ, МТХ.
		4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх.	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	-	ЭБАТ, ТХААХ, ХЭЗХ, МТХ.
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл,	5.1.Удирдлагын зүгээс 2026 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; -Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; -Тайланд нотломжийг	II, IV улирал	ЭБАТ, ХЭЗХ, ТХААХ, Нийт албан хаагчид

1	2	3	4	5	6
	санаачилга өрнүүлэх		хавсаргасан байх.		
		5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм, журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Тухай бүр	ЗСХ, ХЭЗХ
		5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллах;	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -Тайлагнасан байх.	III улирал	ЭБАТ, ХЭЗХ, ТХААХ, ЗСХ.
		5.4.Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам нь Засгийн газрын тогтоол, НИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжаар хүчин төгөлдөр бус болсон эсэхэд хяналт хийх;	-Хяналт хийсэн байх; -Хүчин төгөлдөр бус дүрэм, журмын тоо.	II-IV улирал	ХЭЗХ,
		5.5.Худалдан авах ажиллагааг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах;	-Үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн ажил зохион байгуулах.	II-IV улирал	ЭБАТ, ХЭЗХ
		5.6.Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хуульд нийцүүлэн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах.	-Тушаалын хэрэгжилт үр дүнг тооцох, -Тушаалын үндэслэх хэсэгт хамааралгүй хууль, тогтоол, захирамжийг үндэслэн тушаал гардаг асуудлыг арилгах.	IV улирал	ХЭЗХ